Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2022.06.20

## Олон улсын хөрөнгийн зах зээл

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## ОНЦЛОХ ИНДЕКСҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ

Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

| Америкийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | $29,888.78 | $31,392.79 | -4.79% | $32,654.59 | -8.47% | $33,290.08 | -10.22% |
| S&P 500 | $3,674.84 | $3,900.86 | -5.79% | $4,088.85 | -10.13% | $4,166.45 | -11.80% |
| Nasdaq | $10,798.35 | $11,340.02 | -4.78% | $11,984.52 | -9.90% | $14,030.38 | -23.04% |

| Европийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Dax | € 13,126.26 | € 13,761.83 | -4.62% | € 14,185.94 | -7.47% | € 15,727.67 | -16.54% |
| FTSE 100 | £7,016.25 | £7,245.54 | -3.16% | £7,507.56 | -6.54% | £7,153.40 | -1.92% |

| Азийн индекс | Одоо | 7 хоногийн өмнөх | Өөрчлөлт | Сарын өмнөх | Өөрчлөлт | Жилийн өмнөх | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| CSI 300 | ¥4,309.04 | ¥4,238.99 | 1.65% | ¥4,005.89 | 7.57% | ¥5,101.89 | -15.54% |
| Hang Seng | HKD 21,075.00 | HKD 21,806.18 | -3.35% | HKD 20,602.52 | 2.29% | HKD 28,558.59 | -26.20% |
| Nikkei 225 | JPY 25,963.00 | JPY 27,824.29 | -6.69% | JPY 26,659.75 | -2.61% | JPY 29,018.33 | -10.53% |




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## BITCOIN-ИЙН ХАНШ 17,800 АМ.ДОЛЛАР ХҮРТЭЛ УНАЛАА

Өнгөрсөн бямба гарагт Bitcoin крипто валютын ханш 17,749 ам.доллар, Ethereum крипто валютын ханш 897 ам.доллар хүртэл унасан. Зах зээлийн үнэлгээгээрээ дэлхийд тэргүүлдэг хоёр крипто валют нь долоо хоногийн дотор бараг 35 хувиар унажээ.

Хамгийн дээд цэгтээ Bitcoin 68,789.63 ам.доллар, Ethereum 4,891.7 ам.долларт арилжаалагдаж байсан. Гэтэл одоо крипто валютын зах зээл уналтад орсон нь макро эдийн засгийн тогтворгүй байдал болон Холбооны Нөөцийн Сангийн хэрэгжүүлж буй мөнгөний бодлоготой холбоо хамааралтай.

Крипто валют дээр үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьд бизнес хэцүүхэн нөхцөл байдалд байна. Тухайлбал, өнгөрсөн долоо хоногт крипто валют дээр арилжаа хийх, хадгаламж, зээлийн үйлчилгээ үзүүлдэг Celsius Network компани нь зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн нийт данс хоорондын солилцоо, шилжүүлэг, мөнгө татах үйл ажиллагааг түр зогсоосон гэдгээ мэдэгдсэн. Мөн Coinbase компани нь эдийн засийн хямралд бэлдэн нийт ажилчдынхаа 18 хувийг цомхотгож байгаагаа зарласан.




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## ЭНЭ ДОЛОО ХОНОГТ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИГЛАХ ТАВАН ЗҮЙЛС

**1. Powell-ийн сонсгол**

Холбооны Нөөцийн Сангийн тэргүүн Jerome Powell энэ долоо хоногийн лхагва болон пүрэв гарагуудад Конгрессийн өмнө инфляцийг хэрхэн буулгах талаар сонсголд орно.

ХНС инфляцийг өдөөж буй бүх хүчин зүйлсийг хяналтад оруулж чадахгүй гэдгээ мэдэгдсэн. Тухайлбал, ОХУ болон Украиний дайнаас үүдэлтэй эрчим хүчний үнийн өсөлт.

ХНС-гийн баримталж буй мөнгөний чанга бодлого нь эргээд эдийн засагт сөргөөр нөлөөлж буй шинж тэмдэг бага багаар илэрч байна. Бүр цаашлаад энэ нь эдийн засгийн хямралыг авчрах боломжтой.

Эдийн засгийн тогтворгүй байдал нь мөн хөрөнгийн зах зээлийн тогтворгүй байдлыг өдөөж байна.

**2. Lagarde-гийн сонсгол**

Европын төв банкны тэргүүн Christine Lagarde өнөөдөр Европын Парламентийн сонсголд орно. Тэрээр өсөж буй инфляцтай хэрхэн тэмцэж буйгаа тайлагнаж, санаа зовоож буй асуултуудад хариулах болно.

Европын төв банк дараа сард бодлогын хүүг 25 нэгжээр, мөн есөн сараас өмнө дор хаяж нэг удаа бодлогын хүүг 50 нэгжээр өсгөхөөр төлөвлөж байна. Зарим шинжээчид шаардлагатай бол илүү түрэмгий мөнгөний бодлогыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

**3. АНУ-ын эдийн засгийн үзүүлтүүд**

Энэ долоо хоногт АНУ-ын орон сууцны салбар дээрх эдийн засгийн үзүүлтүүд зарлагдана. Мягмар гарагт одоо байгаа орон сууцны борлуулалтын тоо хэмжээ, баасан гарагт шинээр гарсан орон сууцны борлуулалтын тоо хэмжээг зарлах болно. Мөн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын үйл ажиллагааны талаарх урьдчилсан тоон мэдээлэл пүрэв гарагт гарна.

**4. Хөрөнгийн зах зээлийн тогтворгүй байдал**

Эдийн засгийн хямрал үүсэж болзошгүй нь хөрөнгийн зах зээлийг тогворгүй нөхцөл байдалд оруулж байна.  Nasdaq, S&P 500, Dow Jones индексүүдийн ханш өнгөрсөн долоо хоногт бүгд унасан.

Шинжээчид энэхүү тогтворгүй байдал нь инфляц оройгоо авч дуустал үргэлжлэх болно хэмээн үзэж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**




**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.